



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Монгол Ардын Намын дүрэмд оруулсан
өөрчлөлтийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Х.Сонинбаяр, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Д.Цолмон, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монгол Ардын Намын дүрэмд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Д.Мөнхтуяагийн илтгэснээр хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Ардын Намын дарга У.Хүрэлсүхээс 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын дээд шүүхэд хандан "... Улаанбаатар хотноо 2021 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Монгол Ардын Намын Бага хурлын Х хуралдаан цахимаар хуралдаж Монгол Ардын Намын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5-д "9-11" гэснийг "9-15" гэж, "7-9" гэснийг "7-11" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.5-д "13-17" гэснийг "13-23" гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д "369" гэснийг "479" гэж, 26 дугаар зүйлийн 26.1-д "29" гэснийг "37" гэж, 33 дугаар зүйлийн 33.3-т "15" гэснийг "19" гэж тус тус өөрчлөхөөр шийдвэрлэсэн ... /тул/ Монгол Ардын Намын дүрэмд орсон дээрх өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэж өгнө үү" гэх өргөдөл гаргаж, өргөдөлдөө:

- Монгол Ардын Намын Бага хурлын Х хуралдааны намын дүрэмд өөрчлөлт оруулсан хурлын тэмдэглэл /10 хуудас/
- гишүүдийн цахим бүртгэл /1 хуудас/
- Монгол Ардын Намын Бага хурлын Х хуралдааны 2021 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоол /2 хувь/
- одоо бүртгэлтэй байгаа Монгол Ардын Намын дүрэм /21 хуудас/
- бүртгүүлэхээр ирүүлсэн өөрчлөлтийг тусгасан Монгол Ардын Намын дүрэм /21 хуудас/
- Улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/
- Улсын тэмдэгтийн хураамж 150,000 төгрөг тушаасан баримт зэргийг хавсаргасан байна.

ХЯНАВАЛ:

Монгол Ардын Намын дүрмийн 20 дугаар зүйлийн 20.3.13-д “Намын Их хурлын чөлөө цагт дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэхүү өөрчлөлт нь намын бүтэц зохион байгуулалттай холбоотой болон намын дотоод ардчилал, эв нэгдэлд сөргөөр нөлөөлсөн, гишүүдийн эрх тэгш байдлыг алдагдуулсан, эрхийг хязгаарласан байхыг хориглоно” гэж заасан, Монгол Ардын Намын Бага хурлын Х хуралдаанаас тус намын дүрмийн “8 дугаар зүйлийн 8.5-д “9-11” гэснийг “9-15” гэж, “7-9” гэснийг “7-11” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.5-д “13-17” гэснийг “13-23” гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д “369” гэснийг “479” гэж, 26 дугаар зүйлийн 26.1-д “29” гэснийг “37” гэж, 33 дугаар зүйлийн 33.3-т “15” гэснийг “19” гэж тус тус өөрчлөхөөр хуралдаанд оролцсон гишүүдийн 97 хувийн саналаар шийдвэрлэсэн нь Монгол Ардын Намын дүрмийн дээрх заалт болон Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуулийг зөрчөөгүй байна.

Түүнчлэн, Монгол Ардын Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр Монгол Ардын Намын даргын гаргасан өргөдөл, түүнд хавсаргасан баримтууд нь Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 3.9-д заасан бүрдлийг хангаж байх тул Монгол Ардын Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзах үндэслэлгүй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Ардын Намын Бага хурлын 10 дугаар хуралдаанаар Монгол Ардын Намын дүрмийн “8 дугаар зүйлийн 8.5-д “9-11” гэснийг “9-15” гэж, “7-9” гэснийг “7-11” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.5-д “13-17” гэснийг “13-23” гэж, 20 дугаар зүйлийн 20.1-д “369” гэснийг “479” гэж, 26 дугаар зүйлийн 26.1-д “29” гэснийг “37” гэж, 33 дугаар зүйлийн 33.3-т “15” гэснийг “19” гэж тус тус өөрчилснийг улсын бүртгэлд бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА